



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 0/96

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн Төвийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 20,404,650.00 (хорин сая дөрвөн зуун дөрвөн мянга зургаан зуун тавин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасан байгууллагын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (Ч.Өнөрсайхан)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэгт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150590354

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 15 дүгээр сарын 15-ны өдрийн 15/2024 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв

төгрөгөөр

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих жиг	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024 оны 01 сарын 01-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Компьютерийн дэлгэц Dell	2021.12.01	ш	5	369,270.00	1,846,350.00	962,351.48	883,998.52		
2	Компьютер/дан процессор/ Dell optiflex	2021.12.01	ш	6	1,568,050.00	9,408,300.00	4,903,778.55	4,504,521.45	Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Сонгино хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг
3	Шүдний бор машин	2018.09.20	ш	1	7,500,000.00	7,500,000.00	4,952,515.40	2,547,484.60		
4	Зүрхний бичлэгийн аппарат	2020.11.01	ш	1	1,650,000.00	1,650,000.00	653,054.41	996,945.59		
	Дүн					20,404,650.00	11,471,699.84	8,932,950.16		